



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

06.24 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 11/85

Хархорин сум

Г Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Малын генетик нөөцийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.9.1 дэх заалт, Аймгийн Засаг даргын 2024 оны “Үржлийн малд үзлэг, ангилалт хийж, малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох тухай” А/340 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үржлийн малд үзлэг, ангилалт хийж, малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Лхагвасүрэн Засаг даргын орлогч

Гишүүдэд: С.Мөнхсоёлт Бэлчээр газар тариалан хариуцсан мэргэжилтэн
Ц.Баатарсүрэн Байгаль орчны Улсын байцаагч
Ш.Энхжаргал Дархан бор үржлийн нэгжийн дарга

Нарийн бичгийн дарга: Э.Үүрцайх Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх ажлыг 2024 оны 05 дугаар сарын 25-наас 10 дугаар сарын 05-ны дотор гүйцэтгэхийг Дархан бор үржлийн нэгжийн дарга (Ш.Энхжаргал), ажлын тайланг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт тайлганахыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Э.Үүрцайх)-д даалгасугай.

3. Үржлийн малд үзлэг, ангилалт хийж, малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох ажлыг гүйцэтгэхэд малчдад мэдээлэл хүргэж хамтран ажиллах, хүн хүчний туслалцаа үзүүлэхийг багийн Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ОДГЭРЭЛ



401100198

D: MyDoc.Zahiramj./ZDTG/